



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН  
ТУШААЛ**

2024 оны 06 сарын 11 өдөр

Дугаар A/204


Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

ШУТИС-ийн дүрмийн 4.9.15, 4.9.16, ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-ийн Мэргэжлийн тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. “ШУТИС-ийн Мэргэжлийн тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг нийт багш нарт танилцуулах, мөрдөж хэрэгжүүлэх, хяналт тавьж захиргааны холбогдох нэгжийн удирдлага, бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч нарт даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ШУТИС-ийн Захирлын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ийг шинэчлэн батлах тухай A/234 дугаартай тушаалыг хүчингүйд тооцсугай.
4. Энэхүү тушаалыг 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс мөрдсүгэй.

РЕКТОР



Т.НАМНАН

367040089

ШУТИС-ийн Ректорын 2024 оны 06 дугаар сарын  
11 ны өдрийн 1/004 дугаар тушаалын хавсралт



|  |   |                    |            |
|--|---|--------------------|------------|
|  | <b>МЭРГЭЖЛИЙН ТЭНХИМИЙН ҮЙЛ<br/>АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ<br/>ШУТИС-ХН-ЖУ03</b> | Эхний хэвлэлт      | 2015.02.05 |
|  |   | Өөрчилсөн огноо    | 2024.06.11 |
|  |   | Өөрчлөлтийн дугаар | 5          |

# ШУТИС-ийн МЭРГЭЖЛИЙН ТЭНХИМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

**Боловсруулсан:**

**РЕКТОРЫН АЖЛЫН АЛБА**

**Хянасан:**

**ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН АЛБА**

**Дэмжсэн:**

**ШУТИС-ийн РЕКТОРЫН ЗӨВЛӨЛ**

**Баталсан:**

**ШУТИС-ийн РЕКТОР**



ШУТИС-ийн Ректорын 2021 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн 1/2021 дугаар тушаалын хавсралт

## АГУУЛГА

|   |   |
|---|---|
| НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....                      | 1 |
| ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ.....                         | 1 |
| ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ.....                  | 1 |
| ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ.....           | 1 |
| ТАВ. ТЭНХИМИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....    | 2 |
| ЗУРГАА. ТЭНХИМИЙН ЧИГ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА..... | 3 |
| ДОЛОО. ТЭНХИМИЙН АЛБАН ТУШААЛ.....              | 5 |
| НАЙМ. ГЭРЭЭТ БАГШ АЖИЛЛУУЛАХ.....               | 7 |



ШУТИС-ийн Ректорын 2024.7.24 оны 06 дугаар сарын  
11-ны өдрийн 100 дугаар тушаалын хавсралт



## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Их сургуулийн алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд тэнхимийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэх, шинээр зохион байгуулах, татан буулгах, профессор, багшийг тухайн албан тушаалд ажиллуулахтай холбогдсон харилцаа энэхүү журмаар зохицуулагдана.
- 1.2. Их сургуулийн хэмжээнд бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн тэнхимийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын онцлогт тохирсон зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлт хийх, профессор, багш нарын ажлын байранд тавигдах шаардлагын биелэлтийг хянаж, үнэлгээ дүгнэлт өгөх, ажлын үр дүнгээр албан тушаалын зэрэглэл, шатлалд өөрчлөлт оруулах, албан тушаалын орон тоог жил бүр шинэчлэн тогтоох замаар багш нарыг чадавхижуулах, хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

## ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. ШУТИС-ийн мэргэжлийн тэнхимийн үйл ажиллагаатай холбоотой аливаа үйл ажиллагааг зохицуулна.
- 2.2. ШУТИС-д мэргэжлийн тэнхимд ажиллаж буй бүх багш, ажилтанд хамаарна.

## ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- 3.1. Боловсролын ерөнхий хууль;
- 3.2. Дээд боловсролын тухай хууль;
- 3.3. ШУТИС-ийн дүрэм;
- 3.4. ШУТИС-ийн хөдөлмөрийн дотоод журам, бусад холбогдох хууль, журам.

## ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1. **Мэргэжлийн тэнхим (цаашид тэнхим гэх):** шинжлэх ухааны тодорхой салбараар төрөлжсөн, мэргэжлийн болон техникийн боловсрол, дэд бакалавр, бакалавр, магистр, докторын хөтөлбөрүүдийг эрхлэн хэрэгжүүлдэг, их сургуулийн хэмжээнд сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг эрхлэх нэгж;
- 4.2. **ШУТИС-ийн нэг хичээлийн жилийн үргэлжлэх хугацаа:** тухайн жилийн 7-р сарын 09-ний өдрөөс дараа жилийн 7-р сарын 09-ний өдөр хүртэлх хугацаа;
- 4.3. **Хичээлийн жилийн намрын улирал (үндсэн):** 7-р сарын 01-ний өдрөөс дараа оны 01-р сарын 31-ний өдөр хүртэлх хугацаа;
  - 4.3.1. **Хичээлийн жилийн өвлийн улирал:** 01-р сарын 02-ны өдрөөс 01-р сарын 31-ний өдөр хүртэлх хугацаа;
- 4.4. **Хичээлийн жилийн хаврын улирал (үндсэн):** 02-р сарын 01-ний өдрөөс 6-р сарын 30-ны өдөр хүртэлх хугацаа.
  - 4.4.1. **Хичээлийн жилийн зуны улирал:** 06-р сарын 02-ны өдрөөс 07-р сарын 09-ний өдөр хүртэлх хугацаа;



ШУТИС-ийн Ректорын 2021 оны 06 дугаар сарын  
11-ны өдрийн 100 дугаар тушаалын хавсралт



### ТАВ. ТЭНХИМИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 5.1. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн тэнхимийг шинэчлэн зохион байгуулах, шинээр байгуулах болон татан буулгах асуудлыг тухайн сургуулийн Эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэж, Ректорын тушаалаар баталгаажуулна.
- 5.2. ШУТИС-ийн харьяа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, коллеж, технологийн коллеж (коосен), дээд сургуулийн тэнхимийг шинэчлэн зохион байгуулах, шинээр байгуулах, татан буулгах асуудлыг тухайн сургуулийн дүрэм, холбогдох журамд нийцүүлэн шийдвэрлэнэ.
- 5.3. Тэнхим нь ШУТИС-ийн Ректор, харьяа сургуулийн захирлын тушаалаар баталсан албан тушаалтны бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулна.
- 5.4. Профессор багш нарын албан тушаалын ангиллыг жил бүрийн эхэнд ШУТИС-ийн Ректор, харьяа сургуулийн захирлын тушаалаар шинэчлэн батална.
- 5.5. Тэнхимийн эрхлэгч өөрийн үйл ажиллагаанд туслуулах зорилгоор профессор багш нарт тодорхой чиг үүргийг хуваарилан, хариуцуулан ажиллуулж болно.
- 5.6. Тэнхимийн багш нар их сургуулийн бүтцийн профессорын баг, сургалт, судалгааны, бизнес инкубатор, технологи дамжуулах төв, гарааны компани, гарааны компанид дэмжлэг үзүүлэх зорилго бүхий зөвлөх компани, шинжлэх ухааны парк, технологи, инновацын кластер, туршилт үйлдвэрлэлийн болон эдгээртэй адилтгах нэгжид давхар харьяалагдан ажиллах боломжтой.
- 5.7. Тэнхимд харьяалагдах сургалтын хөтөлбөрүүд, тэнхимийн багш нарын тоо, сургалтын материаллаг бааз, лаборатори зэргээс хамаарч тухайн албан тушаалд харгалзах орон тоог ялгаатай тогтоох ба бүрэлдэхүүн, салбар, харьяа дээд сургуулийн хувьд дараах зарчмыг баримтална. Үүнд:
  - 5.7.1. Сургалтын хөтөлбөр хариуцдаг тэнхимд ажиллах профессорын орон тоог хариуцан хэрэгжүүлж буй ахисан түвшний сургалтын хөтөлбөрийн тоо, профессор багш нарын болон суралцаж буй оюутны тоотой уялдуулан ШУТИС-ийн Ректор тогтооно.
  - 5.7.2. Сургалтын хөтөлбөр хариуцдаг тэнхимд ажиллах дэд профессорын орон тоо нь хариуцан хэрэгжүүлж буй бакалаврын түвшний сургалтын хөтөлбөрийн тоотой тэнцүү байна. Тухайн бакалаврын сургалтын хөтөлбөрт хамаарах мэргэжлийн тоо 4 буюу түүнээс их байх тохиолдолд нэг дэд профессорын орон тоо нэмж болно.
  - 5.7.3. Сургалтын хөтөлбөр хариуцдаггүй тэнхимийн нийт үндсэн багшийн тоо 30-аас бага үед 1 профессор, 1 дэд профессор, нийт үндсэн багшийн тоо 31 буюу түүнээс их үед 2 хүртэл профессор, 2 хүртэл дэд профессор ажиллуулж болно.
  - 5.7.4. Ахлах багш, багш, дадлагажигч багш нарын хувьд тухайн албан тушаалын орон тоог хязгаарлахгүй.
- 5.8. Тэнхимд гадаадын зочин профессор ажиллуулж болох бөгөөд албан тушаалын зэрэглэл, ажлын ачааллыг ШУТИС-ийн Ректорын тушаалаар тогтооно.



ШУТИС-ийн Ректорын 2024 оны 06 дугаар сарын  
11-ны өдрийн 2024 дугаар тушаалын хавсралт



- 5.9. Тэнхимийн хурлыг багш нарын гуравны хоёроос доошгүй ирцтэй хийж, хэлэлцэх асуудлыг олонхын саналаар батлан тэмдэглэл хөтөлнө. Санал тэнцсэн тохиолдолд тэнхимийн эрхлэгчийн саналаар шийдвэрлэнэ.
- 5.10. Тэнхимийн үйл ажиллагааны санхүүжилтийг бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн төсөвт тусгаж батлуулна.
- 5.11. Тэнхимийн үйл ажиллагааны тайланг бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн Захирлын зөвлөлөөр хэлэлцэж дүгнэх ба тэнхимийн эрхлэгчийн ажлын үр дүнг тэнхимийн хамт олноор үнэлүүлж дүгнүүлнэ.

### ЗУРГАА. ТЭНХИМИЙН ЧИГ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 6.1. Тэнхим нь сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновац, нийгмийн түншлэл, мэргэжлийн үйлчилгээний үйл ажиллагаатай холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 6.1.1. Тэнхимийн хөгжлийн чиг хандлага, үнэт зүйл, зорилго, зорилтыг урт ба дунд хугацаагаар төлөвлөх, бизнес болон стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулах;
  - 6.1.2. Тэнхимийн гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төлөвлөлтийн саналыг боловсруулах;
  - 6.1.3. Тэнхим нь мэргэжлийн болон техникийн боловсрол, дэд бакалавр, бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалт явуулах, хөтөлбөрийн үр дүн, чанарт байнгын дүн шинжилгээ, өөрийн үнэлгээ хийж, дотоодод болон олон улсын түвшинд магадлан итгэмжлүүлэх;
  - 6.1.4. Сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах, шинээр хөтөлбөр нээх, хөтөлбөрийг зогсоох талаар хөтөлбөрийн дэд хороо, сургалт арга зүйн зөвлөлд санал хүргүүлэх, хичээлийн стандартыг боловсруулах;
  - 6.1.5. Суралцагчдыг суралцах таатай орчин болон сургалтын иж бүрэн материалаар хангах, сургалт, судалгааны материаллаг баазыг шинэчлэх, шинээр байгуулах, мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлага, заавар боловсруулах ажлыг нэгдсэн төлөвлөлттэй зохион байгуулах;
  - 6.1.6. Сургалтын бус үйл ажиллагаанаас орох орлогыг нэмэгдүүлэх, профессор багш нарын туршилт судалгаа явуулах орчин нөхцөлийг сайжруулах, эрдэм шинжилгээ, инновацын ажлын санхүүжилтийн эх үүсвэр бий болгох;
  - 6.1.7. Эрдэм шинжилгээний семинарыг судалгааны чиглэлээр тогтмол явуулах (хичээлийн жилийн нэг улиралд 2-оос доошгүй), мэргэжлийн сургалт-заах арга зүй, эрдэм шинжилгээ, онол практикийн хурлыг зохион байгуулах, судалгааны үр дүнг дотоод болон гадаадад хэвлэн нийтлүүлэх;
  - 6.1.8. Профессор, багш нарын гүйцэтгэсэн төсөл хөтөлбөр, судалгаа шинжилгээ, туршилт зүгшрүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон мэдлэгийг оюуны өмчийн эрхээр хамгаалуулах;



ШУТИС-ийн Ректорын 2021 оны 06 дугаар сарын  
11-ны өдрийн 1007 дугаар тушаалын хавсралт



- 6.1.9. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор ашиглаж болохуйц, их сургуулийн эзэмшилтэй оюуны өмчийг нэмэгдүүлэх;
- 6.1.10. Багш, судлаачид, оюутан, зохион бүтээгчдийн ноу-хау, шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжих, их сургуулийн инновац, энтрепренёр соёлыг төлөвшүүлэхэд хамтран ажиллах;
- 6.1.11. Профессор багш нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, багшлах бүрэлдэхүүнийг чанаржуулах, эрдэмжүүлэх, мэргэжлийн сургалт, заах арга зүйг сайжруулах ажлыг нэгдсэн удирдлагаар ханган зохион байгуулах;
- 6.1.1. Профессор багш, тэнхимийн бусад ажилтны ажлын чиг үүрэг, албан тушаалын зэрэглэл, шатлалыг тогтоох, өөрчлөх санал гаргах, багш, ажилтны гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх, ёс зүйн болон сахилгын зөрчилтэй холбогдуулан хариуцлага тооцох санал гаргах;
- 6.1.2. Мэргэжлийн тэнхимийн суралцагчдыг эрдэм шинжилгээний ажлын арга барилд сургах, авьяас чадварыг нь нээн хөгжүүлэх, иргэний соёл төлөвшүүлэх, мэргэжлийн уралдаан, олимпиад, соёл, олон нийтийн ажил зохион байгуулах болон оюутны сайн дурын байгууллага, дугуйлан, клубыг дэмжин ажиллах;
- 6.1.3. Нийгэм, олон нийтэд чиглэгдсэн, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ, үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд явуулах;
- 6.1.4. Сургууль-төгсөгч-ажил олгогчийн холбоог бэхжүүлж, төгсөгчдийг насан туршийн сургалтад хамруулах, тэдэнтэй тогтвортой хамтран ажиллах механизм бүрдүүлэх, төгсөгчдийн мэргэжлийн чадвар болон сургалтын хөтөлбөрт санал авах, хамтарсан сургалт, судалгаа явуулах зэргээр ажил олгогчидтой хамтран ажиллах;
- 6.1.5. Монгол Улсын ба тодорхой салбарын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд хамтран оролцох, зөвлөгөө өгөх, төрийн болон холбогдох мэргэжлийн байгууллага, гадаад, дотоодын их, дээд сургууль, эрдэм шинжилгээний болон бизнесийн байгууллагатай түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 6.1.6. ШУТИС-ийн бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэн, тэнхим, профессорын баг, сургалт, судалгааны, бизнес инкубатор, технологи дамжуулах төв, гарааны компани, гарааны компанид дэмжлэг үзүүлэх зорилго бүхий зөвлөх компани, шинжлэх ухааны парк, технологи, инновацын кластер, туршилт үйлдвэрлэлийн болон эдгээртэй адилтгах нэгжүүдтэй үйл ажиллагаагаа уялдуулан хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтарсан судалгаа хийх, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлэх сургалт, хөтөлбөр зохион байгуулах;
- 6.1.7. ШУТИС-ийн дүрэм, журамд өөрчлөлт оруулахтай холбоотой саналыг бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулиар дамжуулан гаргах;
- 6.1.8. Тэнхимийн түүхийн хуанлийг хөтлөх, холбогдох мэдээ тайлан, судалгааг цаг тухай бүр гаргах;
- 6.1.9. ШУТИС-ийн дүрэм, журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;



ШУТИС-ийн Ректорын 2022.07.06 оны 06... дугаар сарын  
11...-ны өдрийн 1/2022 дугаар тушаалын хавсралт



## ДОЛОО. ТЭНХИМИЙН АЛБАН ТУШААЛ

- 7.1. Монгол Улсын холбогдох хууль, бусад эрх зүйн актуудыг баримтлан, ШУТИС-ийн мэргэжлийн тэнхимд ажиллах багшийн албан тушаалын ангилал, албан тушаалын тодорхойлолт, профессор багшид тавих нийтлэг шаардлага зэргийг Ректорын тушаалаар батална.
- 7.2. Тэнхимийн эрхлэгч, бусад албан тушаалтан нь дор дурдсан үндсэн чиг үүргээс гадна ШУТИС-ийн Ректор, харьяа сургуулийн захирлын баталсан албан тушаалын тодорхойлолтод тусгасан бусад ажил үүргийг хариуцан гүйцэтгэнэ.
  - 7.2.1. Тэнхимийн эрхлэгч нь шинжлэх ухааны тодорхой чиглэлээр мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновцын ажил явуулах, материаллаг баазыг бэхжүүлэх, тэнхимийн хүний нөөцийн болон хөгжлийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх, багш, ажилтны гүйцэтгэлийг үнэлэх ба гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэл, суралцагчийн хөгжлийн асуудлыг хариуцан тэнхимийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
  - 7.2.2. Тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд мэргэжлийн чиглэлээр тухайн салбартаа нэр хүндтэй, хариуцсан нэгжийн сургалт, эрдэм шинжилгээний ажил, үйлдвэрлэлийн холбоог хөгжүүлж чадах, шинийг санаачилж багаар ажиллах чадвартай, доктор (Ph.D)-оос доошгүй эрдмийн зэрэгтэй эрдэмтдээс ШУТИС-ийн Ректор, харьяа сургуулийн захирал гурван жилийн хугацаатайгаар, сонгон шалгаруулалтын үр дүнг үндэслэн томилно. Ажилласан хугацааны ажлын үр дүн, хамт олны саналыг нь харгалзан тухайн хүнийг дахин нэг удаа үргэлжлүүлэн томилж болно.
- 7.3. Тэнхимийн профессор нь магистр, докторын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, эрдэм шинжилгээ, судалгааг хариуцах, бүх шатны мэргэжилтэн бэлтгэх сургалтад оролцох, ахисан түвшний сургалтанд мэргэжлийн хичээл заах, сургалт, эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээр ном, сурах бичиг, бүтээл туурвих, хичээлийн агуулгын онлайн нээлттэй эхийг хөгжүүлнэ.
  - 7.3.1. Доктор (Ph.D) болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй, дэд профессор цолтой эрдэмтнийг бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн профессорын албан тушаалд гурван жил хүртэл хугацаагаар ажиллуулна. Ажилласан хугацааны ажлын үр дүн, хамт олны саналыг харгалзан тухайн хүнийг үргэлжлүүлэн ажиллуулж болно.
  - 7.3.2. Судалгаа шинжилгээний ажлын үр дүнгээр онцгой амжилт гаргасан, доктор (Ph.D)-оос доошгүй эрдмийн зэрэгтэй эрдэмтнийг ШУТИС-ийн Ректорын санал болгосны дагуу профессорын албан тушаалд ажиллуулж болно.
- 7.4. Дэд профессор нь бакалаврын түвшний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцах, бүх шатны мэргэжилтэн бэлтгэх сургалт, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцох, удирдах, тухайн салбарын сургалтын материал, ном сурах бичгийн хангамжийг сайжруулах болон цахим сургалтын үйл ажиллагааг хариуцна.
  - 7.4.1. Доктор (Ph.D)-оос доошгүй эрдмийн зэрэгтэй эрдэмтнийг бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн дэд профессорын



ШУТИС-ийн Ректорын 20.02.2011 оны 06 дугаар сарын  
11-ны өдрийн 11 дугаар тушаалын хавсралт



албан тушаалд гурван жил хүртэл хугацаагаар ажиллуулна. Ажилласан хугацааны ажлын үр дүн, хамт олны саналыг нь харгалзан тухайн хүнийг үргэлжлүүлэн ажиллуулж болно.

- 7.5. Ахлах багш нь мэргэжлийн болон техникийн боловсрол, дэд бакалавр, бакалавр, магистр, докторын сургалтад хичээл заах, ном сурах бичиг, гарын авлага бичиж боловсруулах, сургалтын шинэ арга технологи нэвтрүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцох, удирдах үйл ажиллагааг хариуцна.
- 7.5.1. Их сургуулийн багшийн албан тушаалд үр бүтээлтэй ажилласан, докторын (Ph.D) зэрэгтэй багшийг бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн ахлах багшийн албан тушаалд ажиллуулна.
- 7.5.2. Багшийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан, багшлах ажилд шинээр орж байгаа залуу эрдэмтэн болон бусад их, дээд сургууль, коллежид ахлах багшаас доошгүй албан тушаалд ажиллаж байсан доктор (Ph.D)-ын зэрэгтэй багшийг ахлах багшийн албан тушаалд ажиллуулж болно.
- 7.6. Багш нь мэргэжлийн болон техникийн боловсрол, дэд бакалавр, бакалавр, магистр, докторын мэргэжилтэн бэлтгэх сургалтад хичээл заах, ном сурах бичиг, гарын авлага бичиж боловсруулах, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцоно.
- 7.6.1. Багшийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, үндсэн мэргэжлийн дагуу эрдэм шинжилгээний байгууллага, үйлдвэрлэл, бусад их, дээд сургууль, коллежид 5-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан хүнийг бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн багшийн албан тушаалд ажиллуулна.
- 7.6.2. Багшийн албан тушаалын шаардлагыг хангасан дадлагажигч багшийг бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн багшийн албан тушаалд дэвшүүлэн ажиллуулна.
- 7.7. Дадлагажигч багш нь мэргэжлийн болон техникийн боловсрол, дэд бакалавр, бакалаврын түвшний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцон хичээл зааж, багшлах ажлын дадлага, ур чадвар эзэмшинэ.
- 7.7.1. Багшийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, дадлагажигч багшийн албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлага хангасан хүнийг дадлагажигч багшийн албан тушаалд нэг жилээс доошгүй хугацаагаар ажиллуулна.
- 7.8. Сургалтын мастер нь сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах техник хэрэгсэл, лабораторийг хариуцан, багш нарын ажилд дэмжлэг үзүүлнэ. Сургалтын мастер нь бакалаврын түвшний дээд боловсрол болон мэргэжлийн суурь ухааны хичээлийн хөтөлбөрийн дагуу лабораторийн хичээлийг зааж болно.
- 7.9. Бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн саналыг үндэслэн, хүний нөөцийн эрдэм шинжилгээ, судалгааны чадавхыг нэмэгдүүлэх, багш нарт мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, мэргэжлийн хичээл орох, мэргэжлийн ном, сурах бичиг бичих, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зөвлөгч ба гүйцэтгэгчээр оролцуулах зорилгоор их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад ажилласан иргэнийг хөлсөөр ажиллуулах гэрээгээр Зөвлөх профессороор ажиллуулж болно.



ШУТИС-ийн Ректорын 2024 оны 06 дугаар сарын  
11-ны өдрийн 11 дугаар тушаалын хавсралт



7.9.1. ШУТИС-д “Зөвлөх профессор”-оор гэрээгээр ажиллах иргэнд тавих шаардлага, гэрээнд тусгах суурь нөхцөлийг ШУТИС-ийн Ректорын тушаалаар батална.

### НАЙМ. ГЭРЭЭТ БАГШ АЖИЛЛУУЛАХ

- 8.1. ШУТИС-д ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад профессор, багшийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын туршлага, ур чадварыг өвлөн авах, залгамж халааг бэлтгэх, сургалтад оролцуулах, мэргэжлийн хичээл заалгах зорилгоор, мөн сургалтын үйл ажиллагааны явцад профессор багш нар хүрэлцээгүй тохиолдолд мэргэжлээрээ магистр болон түүнээс дээш зэрэгтэй, багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх дадлага, туршлагатай хүмүүсийг хичээлийн жилийн тухайн улиралд гэрээгээр ажиллуулж болно.
- 8.2. Тухайн хичээлийг хариуцсан тэнхимээс гэрээт багш ажиллуулах саналаа бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлын шийдвэр холбогдох баримт материалын хамт сургалтын асуудал эрхэлсэн захиргааны нэгжид хичээлийн жилийн тухайн улирал эхлэхээс өмнө хүргүүлнэ. Сургалтын асуудал эрхэлсэн захиргааны нэгж бүрэлдэхүүн, салбар сургуулиас ирүүлсэн санал, баримтыг хянаж нэгтгэн, ШУТИС-ийн Ректорын тушаалаар баталгаажуулна.
- 8.3. Харьяа сургууль нь гэрээт багшийн үйл ажиллагааг тухайн сургуулийн захирлын баталсан холбогдох журмаар зохицуулна.
- 8.4. Бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн захирал гэрээт багш нартай ажиллах нөхцөл, ажлын ачааллыг тусгасан гэрээг хичээлийн жилийн намрын улирал, хаврын улирал бүрийн эхэнд байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллана.
- 8.5. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн гэрээт багшийн ажлын гүйцэтгэлийг тооцохдоо “ШУТИС-ийн профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”, харьяа сургуулийн хувьд холбогдох журмыг баримтална.

-- оОо --